

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ДОРНОД АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР**

Захиалагч: ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Гүйцэтгэгч: ГАЗРЫН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА “ГЕОБОТАНИК” ХХК

2023 он

АГУУЛГА

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	3
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР	5
ХОТ ТОСГОН БУСАД СУУРИН ГАЗАР	8
ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР	21
ОЙН САН БҮХИЙ ГАЗАР	25
УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР	27
УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР	29

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Мэргэжил, арга зүйн дараах үзэл баримтлал	3
Хүснэгт 2.	Хөдөө аж ахуйн ерөнхий бүсчлэл	5
Хүснэгт 3.	Хөдөө аж ахуйн бүс дэх онцлог газар ашиглалтууд, суурь ойлголт	5
Хүснэгт 4.	Хот, тосгон, бусад суурины тухай ойлголт	8
Хүснэгт 5.	Нэр томьёоны гаргалгаа	9
Хүснэгт 6.	ГЗБ-н бүсчлэлтэй холбоотой нэр томьёо, ойлголт	12
Хүснэгт 7.	Хуульд заасан суурь ойлголт	21
Хүснэгт 8.	ГНС-н зам, шугам сүлжээний газрын дэд ангилал	21
Хүснэгт 9.	Ойн сангийн тухай ойлголт	25
Хүснэгт 10.	Нэр томьёоны гаргалгаа	25
Хүснэгт 11.	Үндсэн нэр томьёо, салбарын стандарт, бусад баримт бичигт заасан үндэслэл	26
Хүснэгт 12.	Усны сан бүхий газрын тухай ойлголт	27
Хүснэгт 13.	Нэр томьёоны гаргалгаа	28

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Газрын тухай хуулийн 24.1 дэх “Газар зохион байгуулалт нь Газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх, газар зүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий цогцолбор арга хэмжээ мөн.” гэж заасныг мэргэжил, арга зүйн дараах үзэл баримтлалаар нарийвчилж төлөвлөв.

Хүснэгт 1. Мэргэжил, арга зүйн дараах үзэл баримтлал

№	Хуульд заасан агуулга	Төлөвлөх цогцолбор арга хэмжээний үзэл баримтлалын агуулга, чиглэл
1	Газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, газрын үл хөдлөх хөрөнгө олж авах, аж ахуй эрхлэх зэрэг Үндсэн хуулийн шаардлагыг хангахаар төлөвлөхөөс гадна хууль дээдлэх зармаар газрын тухай хууль, байгаль орчныг хамгаалах тухай хууль зэрэг Монгол улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй бүхий хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. Газрын ангилал зориулалт бүрээр газар ашиглагч салбар, газрын эрх бүхий этгээдийн өнөөгийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж цаашид төлөвлөгөөнд тусгах бодлого, чиглэл, арга хэмжээний хэрэгцээт байдлыг тогтоож төлөвлөнө. ГЗБЕТ–нд газрын ангилал зүйг Сүхбаатар аймгийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагын системтэй уялдуулна. Оролцогч талууд, иргэдийн оролцоог хангаж төлөвлөнө. Захиалагч талын удирдамж, чиглэл, саналд үндэслэж төлөвлөнө. Газрын зөрчил маргааныг арилгах менежментийн чадавхыг сайжруулах арга хэмжээний чиглэлийг боловсруулна.
2	Газрын кадастр эрхлэх	Өмнөх ГЗБЕТ-ний хэрэгжилтийг кадастрын мэдээллийн сангийн зураг, Сүхбаатар аймгийн газрын нэгдмэл сангийн тооллого, тайлантай давхцуулж дүгнэх, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилттэй харьцуулж дүгнэлт гаргах, цаашид олон зорилгот кадастрыг нэвтрүүлэх бодлого, чиглэл, арга хэмжээг Сүхбаатар аймгийн ГЗБЕТ-нд тусгах, Сүхбаатар аймгийн газрын нэгдмэл сангийн ангилал, хуваарилалтын өнөөгийн байдалд үнэлгээ хийх, цаашид төлөвлөгөөнд тусгах хэрэгцээт байдлыг тодорхойлох Газрын экологи-эдийн засгийн үнэлгээнд суурилж газар ашиглалтын зориулалт, төрлийг өөрчлөх, газрыг эргүүлэн авах, газарт учруулсан хохирлын экологийн болон нөхөн төлбөрийн харилцааг зохицуулах механизмыг нэвтрүүлэх зөвлөмжийг боловсруулах
3	Газрыг үр ашигтай, зохистой ашиглах	Газрыг тогтвортой, ногоон хөгжлийн агуулга зарчмуудыг баримтлан байгаль хамгаалал, нийгмийн болон эдийн засгийн үр ашиг, өгөөжийн төсөөллийг төлөвлөнө. байгалийн хүчин зүйлүүдийн өөр хоорондын болон хүн, байгалийн харилцан үйлчлэлийг зөв тодорхойлон газрын даац, бүтээх чадавх, үр ашигт нийцсэн газар ашиглалтыг төлөвлөнө Газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдалд нийцүүлэн газар ашиглалтын салбар хоорондын зохистой харьцаа, бүтцийг хангаж төлөвлөнө.
4	Газар хамгаалах	Хуульд заасан газрыг хамгаалах нийтлэг шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Газрын хянан баталгааны дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Тусгай хамгаалалтад авах газар, бүх төрлийн зориулалттай хамгаалалтын бүс тогтоох газрын байршил, хил заагийг тогтоон төлөвлөнө.

		Экологийн тааламжтай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн газрыг хамгаалах зохион байгуулалт, эдийн засаг, эрх зүйн иж бүрэн инженерийн цогц арга хэмжээг төлөвлөнө. Ой, усны сан бүхий газрыг экосистемийн тэнцвэрт байдлыг хангах чадавх, үр нөлөөг нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөнө.
5	Газар нөхөн сэргээх	Эрх бүхий этгээдийн нөхөн сэргээх газрын байршил хэмжээ, учруулсан хохирол, нөхөн сэргээх зардлын тойм хэмжээг тогтоож төлөвлөнө. Газрыг нөхөн сэргээхэд газрын эрх бүхий этгээдийн гэрээний үүрэг хариуцлагыг сайжруулах загвар зөвлөмжийг боловсруулах, гэрээг шинэчлэх, дүгнэх зөвлөмжийг боловсруулах
6	Газрын эдийн Засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх	Сүхбаатар аймгийн бүх ангиллын газрын ашиглалтыг экологи-эдийн засгийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын тооцоонд оруулж капиталжуулах, бүртгэх чиглэлийг боловсруулах Газрын хөгжүүлэлт хийх, орчны бохирдлыг бууруулах, гэр хорооллын газрыг дахин төлөвлөлтөд хамруулж барилгажуулах, зам, инженерийн байгууламж, шугам сүлжээний хангамжаар хангах газрын байршлын схем боловсруулах Газрыг ашигласнаар бий болох нэмүү өртөг, үр ашиг, газрын өнөөгийн үнэ цэнэ, үнэлгээ, төлбөрийн төсөөллийг тогтоож төлөвлөнө.
7	Газар зүйн таатай орчин бүрдүүлэх	Газар зохион байгуулалтын төлөвлөлтөөр газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдалд үндэслэн нутаг дэвсгэрийн хуваарь, газар ашиглалтын зориулалтын бүсчлэлийг оновчтой төлөвлөх Нутагшил суурьшил, дэд бүтэц, үйлдвэр, аж ахуйн салбаруудыг экологи, эдийн засаг, орон зайн хувьд оновчтой зохион байгуулж байршуулж төлөвлөнө. Зэрлэг амьтдын амьдрах чухал орчныг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах нөхцөлийг хангаж экологийн гарцуудыг төлөвлөх
8	Газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастрын үйл ажиллагаагаар газрын үндсэн ангилал шилжүүлэх, газар ашиглалтын зориулалтын бүс, ашиглалтын зориулалт, төрөл, ашиглалтын шаардлагыг тогтоох Газрын сервитут тогтоох, горим, дэглэм тогтоох байршлын схем боловсруулах, газрыг эргүүлэн авах, солих, чөлөөлөх, нөхөн олговор олгох зэрэг газар ашиглах, хамгаалах орон зайн таатай орчин бүрдүүлэх үйл ажиллагааг төлөвлөнө.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Суурь ойлголт

“Хөдөө аж ахуйн газар” бөгөөд Монгол улсын газрын нэгдмэл сангийн үндсэн 6 ангиллын нэг нь бөгөөд нийт газар нутгийн дийлэнх хэсгийг эзэлж байдаг.

Монгол улсын газрын нэгдмэл сангийн үндсэн 6 ангиллын нэг нь “**Хөдөө аж ахуйн газар**” бөгөөд Газрын тухай хуулийн **11 дүгээр зүйлд** Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна гэж заасан байна.

Хүснэгт 2. Хөдөө аж ахуйн ерөнхий бүсчлэл

Ерөнхий бүс	Газрын тухай хуульд	Газрын тухай шинэчилсэн хуульд
Уламжлалт хөдөө аж ахуйн салбар	11.1. Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна гэж заасан бөгөөд тусгайлан бүс болгон задлаагүй бөгөөд бэлчээр, хадлангийн газруудыг голчлон нийтээр, зохион байгуулалттайгаар ашиглахаар хуульчилсан байдаг. Суурин ХАА-с зөвхөн тариалангийн газрыг тусгайлан зохицуулсан хуультай.	15.1. Энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын газар нь газар ашиглалтын бүсчлэлтэй байна. 15.2. Хөдөө аж ахуйн газар нь газар ашиглалтын зориулалтаасаа хамаарч дараах бүсчлэлтэй байна: 15.2.1. Уламжлалт мал аж ахуй эрхлэх бүс;
Суурин хөдөө аж ахуйн салбар		15.1. Энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын газар нь газар ашиглалтын бүсчлэлтэй байна. 15.2. Хөдөө аж ахуйн газар нь газар ашиглалтын зориулалтаасаа хамаарч дараах бүсчлэлтэй байна: 15.2.2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс; 15.2.3. Тариалангийн бүс; 15.2.4. Холимог бүс; 15.2.5. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан нөөц бүс

Эрчимжсэн мал аж ахуйн салбарыг бодлогоор хөгжүүлэхээр “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2018 оны 400 тоот тушаалаар баталсан бөгөөд Уламжлалт мал аж ахуйн салбараас ялгаатай нь зөвхөн 5 төрлийн мал аж ахуйгаар хязгаарлагдахгүй бусад суурин мал амьтны аж ахуй хамаардаг.

Эрчимжсэн АА-д тусгай байр бүхий суурин маллагаатай аж ахуйг олгох бөгөөд бэлчээр, тариалангийн хувьд аж ахуйн хүчин чадлаас хамааруулан тусгайлан нормчилсон байдаг.

МАН-н салбарт өндөр ашиг шим бүхий мал өсгөн үржүүлэн эрчимжүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд маллагааны хувьд уламжлалт хэв маяг, нүүдлийн соёлыг хадгалж буй тохиолдолд эрчимжсэн гэж тооцох нь зохисгүй юм.

Хүснэгт 3. Хөдөө аж ахуйн бүс дэх онцлог газар ашиглалтууд, суурь ойлголт

Газар ашиглалт	Суурь ойлголт, тайлбар
Эрчимжсэн мал амьтны аж ахуй	Эдлэн газрын хэмжээ нь урьдчилан нормчлогдсон, нутаг дэвсгэрийн хуваарилалтын дагуу газар эзэмших эрхийн лицензэд заасан болзол, нөхцөлөөр нарийн төрөлжсөн, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх фермер, аж ахуйн нэгжийн газар хамаарах бөгөөд тусгайлан хашаалсан бэлчээр, тариалангийн газар зэрэг эдэлбэр газар байна. Одоогоор Монгол улсад тусгайлсан эдэлбэр газартай эрчимжсэн АА тэр бүр байхгүй байгаа бөгөөд зөвхөн барилга байгууламжийн газрыг нь олгож байгаа нь эрчимжсэн АА-н хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Малчны хороолол, хот орчмын мал бүхий иргэд	Зарим аймаг сумдад хот суурин газрын ойр орчим цөөн тооны мал бүхий /голчлон үхэр зонхилж байдаг/ иргэд суурьшмал байдлаар амьдардаг /ихэнх нутагт малчны хороолол гэж нэршдэг/ бөгөөд өндөр ашиг шим бүхий мал, амьтны аж ахуй эрхэлдэггүй боловч суурин амьдралын хэв маягтай байдаг тул суурин ХАА-н бүсэд хамруулах нь боломжтой боловч эдгээр суурьшмал амьдрал бүхий иргэдийн ашиглаж буй бэлчээр нутаг нь нийтийн эрх зүйгээр зохицуулагдаж байдаг. Мөн хот суурины ойролцоох хамгийн ихээр талхлагдал доройтолд өртөж буй газрууд байдаг тул тусгайлан бэлчээр ашиглалтын бүс тогтоох, малын тоонд хязгаарлалт тавих шаардлагатай. Тус газар ашиглалтын хэлбэр нь зарим тохиолдолд эрчимжсэн АА-тай зэрэгцэн оршиж байдаг, мөн зарим тохиолдолд хот тосгон бусад суурины эдэлбэр газарт байдаг тул байршил, ашиглалтын онцлогоос нь хамааруулан ХАА-н газрын суурин ХАА-н бүс, тусгай горимоор зохицуулсан уламжлалт ХАА-н бүс эсвэл хот тосгон бусад суурины эдэлбэр дэх ХАА-н бүсэд хамруулах зүйтэй.
Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж	1. Өвөлжөө, хаваржааны доорх газар, хашаа саравч 2. Бэлчээр дэх худаг 3. Мал угаах ванн, мал эмнэлэг, мал аж ахуйд зориулсан бусад үйлчилгээний цэг Үүнээс: Мал эмнэлэг, бойны газар зэрэг зарим үйлчилгээний цэгүүд хот тосгон бусад суурины эдэлбэр газарт эсвэл түүний ойр орчимд байх нь тохиолдол байдаг. Иймд газрын тухай хуулийн дагуу хот тосгон бусад суурины эдэлбэр газарт байгаа эсэхээс хамааруулах газрын нэгдмэл сангийн аль ангиллын газарт хамааруулахыг шийдэх нь зүйтэй. Мал угаах ванн, мал эмнэлэг, мал аж ахуйд зориулсан бусад үйлчилгээний цэгийн газарт эрүүл ахуйн бүс тогтоож өгөх, тусгай горим дэглэм тогтоох шаардлагатай
Хагас эрчимжсэн аж ахуй	Хагас эрчимжсэн аж ахуй гэх нэр томьёо ашиглах нь түгээмэл тохиолддог.газар ашиглалтын хэрэгцээ, тавигдах шаардлагын хувьд хагас нь эрчимжих гэдэг ойлголт байж болохгүй. Зарим тохиолдолд өндөр ашиг шим бүхий малыг уламжлалт бэлчээрийн мал АА-н аргаар маллах, эсвэл суурин байрлаж буй малчны хороолол зэрэг газарт өндөр ашиг шимт мал маллаж буй тохиолдолд энэ нэр томьёог ашиглах элбэг байна. Тариалангийн тухай хуулийн 17.5-д тариалангийн бүс нутагт суурин болон хагас суурин эрчимжсэн мал аж ахуйг тусгайлсан бэлчээрт эрхэлнэ гэж заасан байдаг. Иймд газар ашиглалтын онцлогийг харгалзан суурин эсвэл уламжлалт МАА-н бүсэд хамааруулах нь зүйтэй.

Нэр томьёоны гаргалгаа

Хүснэгт 4. Үндсэн нэр томьёо, хуулийн үндэслэл

Нэр томьёо	Тайлбар
Хөдөө аж ахуйн газар	Газрын тухай хуулийн 11 дүгээр зүйлд Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна
Хөрс	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 4.1.1. Газрын гадаргын өнгөн хэсгийн үржил шимт давхарга бүхий сэвсгэр хэсгийг;
Хөрсний доройтол	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 4.1.2 Хөрсний үржил шим муудах, элэгдэл, эвдрэлд орох, бохирдох, бэлчээр талхлагдаж анхны шинж чанараа алдахыг;
Цөлжилт	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 4.1.3 Уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа зэрэг бусад хүчин зүйлийн нөлөөгөөр хөрс доройтох үйл явцыг;
Хөрс хамгаалах	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 4.1.4. Хөрсийг хүний болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр доройтохоос хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг;
Хөрсийг нөхөн	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 4.1.5. Доройтсон хөрсийг анхны төрх байдалд нь оруулах, үржил шимийг нь нэмэгдүүлэн

сэргээх	сайжруулах үйл явцыг;
Тариалангийн талбай	Тариалангийн тухай хуулийн 3.1.3. Тариалангийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа нэгж газрыг;
Атар газар	Тариалангийн тухай хуулийн 3.1.3. Холбогдох судалгаагаар тариаланд тохиромжтой газар гэдэг нь тогтоогдсон, тариалан эрхлэх зориулалтаар ашиглагдаагүй байгаа газрыг;
Атаршсан газар	Тариалангийн тухай хуулийн 10.1.Атаршсан газарт гурван жил тариалалт, уринш хийгээгүй тариалангийн газар хамаарна.
Хөрсний шим тэжээлийн бодис	Тариалангийн тухай хуулийн 3.1.4 Ургамлын өсөлт, хөгжилтөд шаардагдах хөрсөн дэх бодисыг;
Хөрсний үржил шим	Тариалангийн тухай хуулийн 3.1.5 Ургамлын ургац бүрдүүлэхэд шаардагдах чийг, хөрсний шим тэжээлийн бодис, агаар, дулаан, физик-механик шинж, хими, биологийн орчныг тодорхойлж байгаа хөрсний чадавхыг;
Тариалангийн бүс нутаг	Тариалангийн тухай хуулийн 3.1.6. Таримал ургамал ургуулах хөрс, цаг уурын тохиромжтой нөхцөл бүрдсэн нутагт газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийн зохистой уялдааг хангах зорилгоор төрөөс тусгайлан тогтоосон бүс нутгийг;
Эрчимжсэн мал аж ахуй	Тариалангийн тухай хуулийн 3.1.7. Суурин болон хагас суурин байдлаар өндөр ашиг шимт мал, тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх үйл ажиллагааг. 17.5.Тариалангийн бүс нутагт суурин болон хагас суурин эрчимжсэн мал аж ахуйг тусгайлсан бэлчээрт эрхэлнэ.
Бүс нутаг	Аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот тосгоны хоорондын нийгэм, эдийн засгийн харилцаа холбоо, тусгай хамгаалалттай газар нутаг, тэдгээрийн орчны бүс, хүн амын нутагшилт, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон аж ахуйн бусад салбар (салбар хооронд)-ын уялдаа холбоо, орон зайн хөгжил, байршлын хүрээг хамарсан Монгол улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг буюу эдийн засаг, нийгмийн цогцолборыг хэлнэ
Бэлчээр	Газрын тухай хуулийн 3.1.6."бэлчээр" гэж мал, амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн газарт хамааруулсан газрыг;
Хадлан	Монгол хэлний тайлбар толь Хадаж авч мал тэжээхэд зориулан нөөцөлсөн өвс
Хадлангийн газар	Монгол хэлний тайлбар толь Байгалийн болон таримал ургамлыг хадаж өвс бэлтгэх зориулалттай талбай
Аймаг дундын отрын бэлчээр	Газрын тухай хуулийн 18.1.2-т заасны дагуу Засгийн газар уг ангиллаар тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, хил заагийг батлах эрхтэй
Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	Газрын тухай хуулийн 18.1.2-т заасны дагуу Засгийн газар уг ангиллаар тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, хил заагийг батлах эрхтэй
Хөдөөгийн тосгон	ХАА эрхлэхэд тохиромжтой бүс нутагт дахь хүн амын суурьшлыг бүрдүүлж буй засаг захиргааны бие даасан нэгж

Хотын хөдөө аж ахуйн бүс	Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.5. "бүсчлэл" гэж хот, тосгоныг хөгжүүлэх төлөвлөлтийн үе шатанд нутаг дэвсгэрийг ашиглалтын үүрэг, зориулалтаар бүсчлэн хувааж, ашиглалтын төрлийн хязгаарлалт тогтоохыг; 13.1. Хот, тосгоны нутаг дэвсгэрт дараах бүсчлэлийг хот байгуулалтын норм ба дүрэм, журмын дагуу төлөвлөж тогтооно: 13.1.5. Хөдөө аж ахуйн бүс;
--------------------------	---

ХОТ ТОСГОН БУСАД СУУРИН ГАЗАР

Суурь ойлголт

Монгол улсын газрын нэгдмэл сангийн үндсэн 6 ангиллын нэг нь "Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газар" бөгөөд Газрын тухай хуулийн 12.1-т "Хот, тосгон, бусад суурин, Нийслэл хотын эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаарна"

/Энэ зүйлийг 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/ гэж заасан байна.

Хүснэгт 5. Хот, тосгон, бусад суурины тухай ойлголт

	Монгол хэлний тайлбар толь /mongoltoli.mn/	Хуулийн ойлголт
Хот	Нэгэн газар барилга байшин цогцлон суурьшсан бөгөөд үйлдвэр, худалдаа, засаг захиргааны байгууллага төвлөрч хүн ам олноор хуран цугларсан газар	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1. Хот нь 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар мөн.
Тосгон	Том, бага суурин газар	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.2. Тосгон нь 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн.
Бусад суурин	Хүн олноороо суурьшсан газар	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд тусгайлан заагаагүй. 500 хүртэл хүн амтай суурьшлыг тооцохоор байна. 10.5. 500 хүртэл хүн амтай сууринд оршин суугчдын нийгэм, ахуйн асуудлыг тухайн сууринд голлох аж ахуйн нэгжийн удирдлага, түүнчлэн харьяалах баг, сумын иргэдийн Нийтийн болон төлөөлөгчдийн хурал, Засаг дарга тус тус шийдвэрлэнэ гэж заасан. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 4.1.15. "Суурин газар" гэж эдэлбэр газартай, оршин суугч, дэд бүтэцтэй, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал зэрэг салбар хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурьшлыг.

Хот, тосгон, бусад суурин газрыг хөгжүүлэхтэй холбоотой урт хугацааны төлөвлөлтийн баримт бичгүүд Монгол улсын хууль тогтоомжид зааснаар "Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө" болон "Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" байдаг.

Газрын тухай хуулийн 56.1-т Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн **газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож батлагдсан** хот, тосгоны

хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу энэ хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

Хүснэгт 6. Нэр томьёоны гаргалгаа

Нэр томьёо	Тайлбар
Бүс нутаг	Аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот тосгоны хоорондын нийгэм, эдийн засгийн харилцаа холбоо, тусгай хамгаалалттай газар нутаг, тэдгээрийн орчны бүс, хүн амын нутагшилт, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон аж ахуйн бусад салбар (салбар хооронд)-ын уялдаа холбоо, орон зайн хөгжил, байршлын хүрээг хамарсан Монгол улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг буюу эдийн засаг, нийгмийн цогцолборыг хэлнэ
Хот тосгон бусад суурины эдэлбэр газар	Газрын тухай хуулийн заалт 12.1-т Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтэц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаарна гэж заасан
Хөдөөгийн тосгон	ХАА эрхлэхэд тохиромжтой бүс нутагт дахь хүн амын суурьшлыг бүрдүүлж буй засаг захиргааны бие даасан нэгж
Хөдөөгийн суурин	ХАА эрхлэхэд тохиромжтой бүс нутагт тухайн нутаг дэвсгэр байршиж буй засаг захиргааны нэгжид харьяалагдах хүн амын суурьшлыг
Хот байгуулалтын бүсчлэл	Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.5 зааснаар - Хот, тосгоныг хөгжүүлэх төлөвлөлтийн үе шатанд нутаг дэвсгэрийг ашиглалтын үүрэг, зориулалтаар бүсчлэн хуваана. - Бүсийн ашиглалтын төрлийн хязгаарлалт тогтооно
Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрын ГЗБ-н бүсчлэл	Газрын тухай хуулийн 9.2. Газрын нэгдмэл санг газар ашиглалтын үндсэн зориулалт, хэрэгцээг харгалзан ангилна. - Хот, тосгон, бусад суурины эдэлбэр газрын төлөвлөлтөөр газар ашиглалтын эрх, үндсэн зориулалтаар бүсчлэн хуваана - Бүсэд хэрэгжүүлэх ГЗБ-н цогцолбор арга хэмжээг төлөвлөнө.
Орон сууцны хороолол	Бичил хороолол: Орон сууцны хэд хэдэн бүлэглэлээс бүрдсэн хотын бүтэц дэх хот төлөвлөлтийн нэгэн нэгжийг хэлнэ. Өдөр тутмын үйлчилгээний радиус нь 500 м-ээс ихгүй байна Орон сууцны хороолол: Хэд хэдэн бичил хорооллоос бүрдсэн хотын бүтэц дэх хот төлөвлөлтийн нэгэн нэгжийг хэлнэ. 30 000-80 000 хүн амтай, 80-250 га талбай бүхий орон зайн цогцолбор. Үйлчилгээний радиус нь 1500м-ээс ихгүй үйлчилгээний барилгууд буюу хотын чанартай үйлчилгээний барилгууд байрласан, гол гудамж ба хотын чанартай гудамж, нэвтрэхэд төвөгтэй ердийн болон хиймэл заагаар хязгаарлагдсан суурьшлын элемент юм.
Орон сууц	Орон сууцны тухай хуулийн 3.1.1."орон сууц" гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг; "Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт" /БНБД 31-01-10/ 4.2. Орон сууцны барилгын байрлал, түүний эзэмшил газрын хэмжээг БНБД 30-01- 04, БНБД 23-04-07-ийн дагуу тогтооно. Барилгын нийт эзлэхүүн давхрын тоо ба урт нь барилгажилтын төслөөр тогтоогдоно. Газар хөдлөлтийн бүс нутаг дахь орон сууцны барилгын давхрын тоо ба нийт уртыг БНБД 22-01-01-ийн дагуу тодорхойлно. Орон сууцны барилгын өндрийг дараах байдлаар ангилна. Үүнд: 1-3 давхар барилгыг нам давхар; 4-6 давхар барилгыг цөөн давхар;

	- Долоогоос арван долоон давхар хүртэлх буюу 16 давхар барилгыг олон давхар барилга; - Арван долоо ба түүнээс дээш давхар барилгыг өндөр барилга
Ашиглалтын шаардлага хангаагүй орон сууцыг буулгаж шинээр барих төсөл хэрэгжүүлэх	Барилгын тухай хуулийн 4.1.10."барилга байгууламж шинээр барих" гэж барилга байгууламж барих, эсхүл хуучин барилга байгууламжийг буулгаж барихыг; Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 16.1.Ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барина.16.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга барилга, хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн барилга байгууламжийг ашиглахыг хориглосон шийдвэр гаргана. 16.5.Нийтийн зориулалттай орон сууцыг буулгах, шинээр барихад Орон сууцны тухай хуулийн 151дүгээр зүйлийг баримтална.
Гэр хороолол	Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 4.1.2. "Гэр хороолол" гэж хот, суурин газрын эдэлбэр газар дахь инженерийн болон нийгмийн дэд бүтцээр бүрэн хангагдаагүй гэр, орон сууц бүхий суурьшлыг
Гэр хорооллын газрын дахин зохион байгуулах /хөгжүүлэлтийн төсөл хэрэгжүүлэх/	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 17.1.Гэр хороололд оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай амьдрах орчин нөхцөл болон газар ашиглалтыг сайжруулах, газрын үнэлгээг өсгөх зорилгоор инженерийн бэлтгэл ажил, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламж барихад зориулж иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшлийн газрыг дахин зохион байгуулна.
Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэх	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 18.1.Гэр хороололд инженерийн бэлтгэл ажил, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, орон сууц, нийтээр ашиглах барилга байгууламж барих, тохижилт хийх, эдийн засаг, нийгэм, байгаль орчны зохистой харьцааг хангах зорилгоор гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулна.
Инженерийн дэд бүтэц	Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.10."инженерийн дэд бүтэц" гэж эрчим хүч, цэвэр, бохир усны болон зам, замын байгууламж, тээвэр, харилцаа холбооны шугам сүлжээ, барилга байгууламжийг
Нийгмийн дэд бүтэц	Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.11."нийгмийн дэд бүтэц" гэж соёл, боловсрол, худалдаа, ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн цогцолборыг;
Капитал барилга	Он удаан жил ашиглагдах хийц бүтээц, чанар сайтай барилга байгууламж
Бие даасан нэгж талбар	Эдэлбэр газрын хил заагаараа нь кадастрын бүртгэлд бүртгэгдсэн, зөвшөөрөгдсөн үндсэн зориулалтаараа ашиглагдаж буй нэгж талбар
Рекреаци	Амралт зугаалга, хүн амын нөхөн сэргэлт, экологийн үйлчилгээ авах орон зайн орчин
Хотын төв цэцэрлэгт хүрээлэн /общегородской парк/	Хотын бүх иргэдэд /Нийтийн/ зориулагдсан соёл-үйлчилгээ, амралт цэнгүүн, биеийн тамир урлаг спортын арга хэмжээ зохион явуулдаг, тоглоом ба үзвэрийн газар бүхий ногоон байгууламжийн хөвч юм.
Үндэсний баяр наадмын цэнгэлдэх хүрээлэн	Газрын нийтийн эрх зүйн харилцаагаар зохицуулагдах үндэсний баяр наадмын үйл ажиллагаа зохион байгуулахад зориулагдсан газар. - Үндэсний баяр наадмын үйл ажиллагаа явагдах, үйлчилгээ үзүүлэх барилга байгууламж, - Морин уралдааны зурвас газар зэрэг бусад үйл ажиллагаанд зориулан засаж тохижуулсан талбай, - Бөх, сур харваа, шагай харваа болон бусад урлаг, спортын арга

	хэмжээ зохион байгуулах барилга байгууламж болон тохижилттой болон тохижилтгүй задгай талбай, • Нийтийн зориулалттай авто зам, зогсоолын талбай, иргэд амрах зориулалттай задгай талбай • Бүх төрлийн худалдаа, нийтийн үйлчилгээ эрхлэх газар
Цэцэрлэгт талбай /сквер/	Иргэдийг түр амарч алжаал тайлах зориулалттай тохижуулсан талбайтай ногоон байгууламж.
Цэцэрлэгт гудамж /бульвар/	Явган хүний хөдөлгөөнийг цэгцлэх ба иргэдийг түр амарч алжаал тайлах зориулалттай газар бүхий ногоон байгууламж юм
Цэцэрлэгт явган хүний зам /аллей/	Цэнгэлдэх хүрээлэнгийн ногоон байгууламж бүхий гол ба салбар замыг хэлнэ.
-Газрыг орон сууцаар солих -Газрыг газраар солих -Газрыг худалдах, худалдан авах	Газрын тухай хуулийн 42.2.Засгийн газар нь бусдын эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, газар эзэмшигчтэй түүний хийсэн урьдчилсан тохиролцоог харгалзан зохих шийдвэр гаргана. 42.2.Засгийн газар нь бусдын эзэмшил газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, газар эзэмшигчтэй түүний хийсэн урьдчилсан тохиролцоог харгалзан зохих шийдвэр гаргана. 42.1. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээний хугацаа дуусахаас өмнө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил газрыг улсын тусгай хэрэгцээнд бүгдийг буюу зарим хэсгийг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах саналыг тухайн газар эзэмшигчтэй урьдчилан тохиролцсоны дараа Засгийн газарт гаргаж болно.

ГЗБ-н бүсчлэлтэй холбоотой нэр томьёо, ойлголт

Хүснэгт 7. ГЗБ-н бүсчлэлтэй холбоотой нэр томьёо, ойлголт

ГНС-н үндсэн ангилал Газрын тухай хуулийн 10-р зүйл	ГНС-н дэд ангилал Газрын тухай хуулийн 12-р зүйл	Хот байгуулалтын үндсэн бүс Хот байгуулалтын тухай хуулийн 13-р зүйл	Хот байгуулалтын үндсэн бүс дэх дэд ангилал	Газар ашиглалтын үндсэн бүс	Газар ашиглалтын дэд бүс	ГЗБ-ын ерөнхий төлөвлөгөөний газрын менежментийн бодлого	Бүсэд, газар олгох, газрын гэрээнд тавигдах шаардлага,
Хот тосгон, бусад суурины газар /2022 оны 1 сарын 1-с хэрэгжих Газрын тухай хуулийн шинэчлэлт 12.1. Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаарна. 12.2. Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад	Барилга, байгууламжийн дэвсгэр газар Газрын тухай хуулийн 12.1 Засгийн газрын 2003 оны 204-тогтоол Тайлангийн маягт батлах тухай /Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлан/	Орон сууцны бүс олон нийтийн бүс	Хот байгуулалтын тухай хуулийн 14.1 Орон сууц, олон нийтийн бүсэд эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангаж, байгалийн гэрэлтүүлгийн холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу төлөвлөгдсөн орон сууц, сургалт, соёл, үзвэр, шинжлэх ухаан, эмнэлэг, амралт, сувилал, спорт, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, тээвэр, холбооны чиглэлийн үйл ажиллагаа явуулах зориулалттай барилга байгууламж төлөвлөх бөгөөд амьдрах, аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж болохуйц бусад барилга байгууламж төлөвлөхийг хориглоно.	Орон сууц, олон нийтийн бүс /1/	Олон нийт, ажил хэргийн бүс /1.1/	- Төрийн байгууллагуудын хэвийн ажиллах нөхцөлийг хангах төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх - Нийгмийн болон инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх Хот байгуулалтын шаардлага, газар ашиглалтын нягтралаас хамааруулан орон сууцны хороолол төлөвлөх	1. Хот байгуулалтын тухай хуулийн 14.1-д тодорхойлсон орон сууц, олон нийтийн бүсэд эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангаж, байгалийн гэрэлтүүлгийн холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу төлөвлөгдсөн орон сууц, сургалт, соёл, үзвэр, шинжлэх ухаан, эмнэлэг, амралт, сувилал, спорт, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, тээвэр, холбооны чиглэлийн үйл ажиллагаа явуулах зориулалттай барилга байгууламж бүхий нутаг дэвсгэр 2. Голлох газар ашиглалт нь олон нийтэд үйлчлэх байгууллага, төрийн байгууллага төвлөрч үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд бүс болгох үндсэн шалгуурыг хангасан газар байна. Орон сууц, олон нийтийн бүсийн дэглэмтэй адил
					Дунд, өндөр давхрын орон сууц, олон нийтийн бүс /1.2/	- Хот байгуулалтын шаардлага, газар ашиглалтын Нягтралаас хамааруулан барилгажилтын нягтралыг хязгаарлах, дэмжих төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх - Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах	1. Хот байгуулалтын тухай хуулийн 14.1-д тодорхойлсон орон сууц, олон нийтийн бүсэд эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангаж, байгалийн гэрэлтүүлгийн холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу төлөвлөгдсөн орон сууц, сургалт, соёл, үзвэр, шинжлэх ухаан, эмнэлэг, амралт, сувилал, спорт,

суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна./					төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх - Нийгмийн болон инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх - Оршин суугчдын эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангах зориулалттай бусад төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх	худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, тээвэр, холбооны чиглэлийн үйл ажиллагаа явуулах зориулалттай барилга байгууламж бүхий нутаг дэвсгэр 2. ГЗБЕ төлөвлөгөөгөөр зөвшөөрөгдсөн газар ашиглалтын зориулалтыг тогтооно Бүс дэх зөвшөөрөгдсөн газар ашиглалтын ангилал, зориулалт, төрөлжилтийн хил заагийг нарийвчилсан ГЗБ зураг төсөл, барилгажилтын зураг төсөл, ТЭЗҮ-гээр нэгж талбараар тогтооно
	Гэр хорооллын газар Газрын тухай хуулийн 12.1 Засгийн газрын 2003 оны 204-тогтоол Тайлангийн маягт батлах тухай /Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлан/	Орон сууцны бүс	Гэр хорооллын бүс Нам давхрын орон сууцны бүс	Нам давхрын орон сууцны бүс /1.3/ /Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04-ийн дагуу гэр хорооллын газрыг энэ бүсэд хамруулан ойлгоно/	- Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх - Гэр хорооллыг дахин зохион байгуулах төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх Нийгмийн болон инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх - Шинэ суурьшлын бүсийг хөгжүүлэх, дэд бүтцээр хангах төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх	Гэр хороолол Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 4.1.2."гэр хороолол" гэж хот, суурин газрын эдэлбэр газар дахь инженерийн болон нийгмийн дэд бүтцээр бүрэн хангагдаагүй гэр, орон сууц бүхий суурьшлын бүсийг хэлнэ. /Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04-ийн дагуу инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангагдаагүй гадуурхагдсан нийгмийн давхарга байж болохгүй/ Нам давхрын орон сууцны бүс Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 4.1.2-т тодорхойлсон газарт хөгжүүлэлт хийсэн хувийн эдэлбэр газартай орон сууц бүхий суурьшлыг хэлнэ. /Инженерийн хангамж төвлөрсөн болон бие даасан, хэсэгчилсэн дундаа ашигладаг аль ч төрөл байж болно./
		Зуслангийн бүс	Зуслангийн бүс Хот байгуулалтын тухай хуулийн	Зуслангийн бүс- (Рекреацийн) /1.5/		1. Экологийн үйлчилгээ авах боломжийг хангах зориулалтаар тусгайлан тогтоосон бүс бөгөөд үндсэн зорилго нь өөр тул нам

			14.6.Зуслангийн бүсэд иргэд зуны улиралд түр хугацаагаар суурин амьдарч болох хотын төвөөс зайдуу орших төвлөрсөн дэд бүтэцгүй суурьшлын газар нутгийг төлөвлөнө.				давхрын орон сууцны бүстэй адилтгаж болохгүй 2. Бүсэд газар ашиглах, ангилал, зориулалтыг журмаар зохицуулна 3. Хүн амын эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангах зориулалтаар худалдаа, нийтийн үйлчилгээний байгууллагууд, бусад шаардлагатай тусгай чиг үүргийн байгууллагуудыг төлөвлөнө
				Суурьшлын нөөц бүс /2/	Суурьшлын нөөц бүс /2.1/	Газар зохион байгуулалт, хотын хөгжлийн нарийвчилсан зураг төсөл боловсруулж хэрэгжүүлэх	Газрын тухай хуулийн 25.1.5-д заасан зураг төсөл боловсруулах
	Нийтийн эдэлбэр газар Газрын тухай хуулийн 12.2 Засгийн газрын 2003 оны 204-тогтоол Тайлангийн маягт батлах тухай /Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлан/	Инженерийн шугам сүлжээ болон зам тээврийн бүс	Инженерийн шугам сүлжээ болон зам тээврийн бүс	Зам, шугам сүлжээ Тэдгээрийн хамгаалалтын бүс /3/	Инженерийн шугам сүлжээ болон зам тээврийн бүс /3.1/	- Инженерийн шугам сүлжээний трасс сонгох, ажлын зураг төсөл боловсруулах, Шаардлагатай газарт газар чөлөөлөлтийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх	1. Хот байгуулалтын тухай хуулийн 14.3. Инженерийн шугам сүлжээний болон зам тээврийн бүсэд төмөр зам, усан болон авто тээвэр, агаарын тээвэр, инженерийн /цэвэр, бохир усны, дулаан, холбоо, цахилгааны гэх мэт/ шугам сүлжээний барилга байгууламжийг төлөвлөнө. 2. Газрын тухай хуулийн 13.1. Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, зам, замын зурвас газар, тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна гэж заасны дагуу хот тосгон бусад суурин газрын эдэлбэр доторх газрыг хамруулна.
					Дэд бүтцийн барилга бүхий нэгж талбарын газар, тэдгээрийн	- Хамгаалалтын бүсийн горим дэглэмийг хангах - Шинээр байгуулах газарт тусгайлан зураг	Дэд бүтцийн зориулалттай бие даасан нэгж талбар бүхий бүс газар, тусгайлан хуулиар тогтоосон хамгаалалтын бүстэй

ДОРНОД АЙМГИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2-Р ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ТАЙЛАН
2023 ОН

	Нийтийн эдэлбэр газар Газрын тухай хуулийн 12.2 Засгийн газрын 2003 оны 204-Тогтоол Тайлангийн маягт батлах тухай /Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлан/ Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай болон цэцэрлэгт хүрээлэнгийн газар	Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс;	Хот байгуулалтын тухай хуулийн 14.4.Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүсэд хот орчмын ой, ойн хамгаалах зурвас, амралт, сувилал, усан сан, цэцэрлэгт хүрээлэн, спортын цогцолбор, наран шарлагын газар зэрэг олон нийтийг хамрах амралт зугаалгын үйл ажиллагааг зохион байгуулахад зориулагдсан орон зайн задгай орчин, түүнчлэн байгалийн дархан цаазат болон онцгой хамгаалалттай газар нутгийг төлөвлөнө.	Амралт, аялал жуулчлалын бүс /4/	хамгаалалтын бүс /3.2/	төсөл, ТЭЗҮ-ийн дагуу байгуулах	
					Олон улс болон хот хоорондын зорчигч болон ачаа тээвэр, логистикийн бүс /3.3/	Төлөвлөлтийн зураг төсөл, ТЭЗҮ-ийн дагуу газар хөгжүүлэлт хийх	
					Үндэсний болон олон улсын хэмжээний баяр наадам, хурал, урлаг, спортын болон бусад арга хэмжээг Зохион байгуулах бүс /4.1/	Төлөвлөлтийн зураг төслийн дагуу хөгжүүлэлт хийх	- Үндэсний болон олон улс, улсын хэмжээний баяр наадам, хурал, урлаг, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах нөхцөлийг хангах зорилгоор тусгайлан тохижуулсан, цогцолбор бүхий бүс
					Нийтийн зориулалттай хотын ногоон байгууламж /4.2/	Төлөвлөлтийн зураг төслийн дагуу хөгжүүлэлт хийх	Газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөөний дагуу нийтээр ашиглах зорилгоор зориудаар бүтээн байгуулсан хүн, амьтны эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангах зориулалттай хөгжүүлэлт хийгдсэн нийтийн эрх зүйн харилцаагаар зохицуулагдах суурьшлын бүс доторх газар 1. Цэцэрлэгт хүрээлэн 2. Цэцэрлэгжүүлж зүлэгжүүлсэн талбай 3. Тусгай зориулалтын ногоон зурвас 4. Нийтээр ашиглахаар тохижуулсан амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар
					Хот орчмын ногоон орчны нийтийн амралт зугаалгын бүс /4.3/	Төлөвлөлтийн зураг төслийн дагуу хөгжүүлэлт хийх	Хот суурины эдэлбэр газар буюу /тэг гортиг/ дотор мөн суурьшлын бүсийн гаднах хот суурин байгуулахад хүндрэлтэй газар нутаг бөгөөд нийтийн эрх зүйн харилцаагаар зохицуулагдах

						газар газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөөний дагуу нийтээр ашиглах зорилгоор ногоон бүс байгуулах, амралт, зугаалгын бүс болгон хөгжүүлэх төлөвлөлт хийгдэнэ. Үндсэн элементүүд: 1. Ойжуулалт хийх, ногоон байгууламж бий болгох газар 2. Амралт, биеийн тамирын зориулалттай зам талбай 3. байгуулах газар Хөшөө дурсгал: АНГЗЕТ боловсруулах зөвлөмжийн 5.1-т тодорхойлсон "Түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, цогцолбор дурсгал" 4. Архитектурын чуулга: АНГЗЕТ боловсруулах зөвлөмжийн 5.1-т тодорхойлсон "Түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж бүхий уран барилгын цогцолбор
Барилга, байгууламжийн дэвсгэр газар Газрын тухай хуулийн 12.1 Засгийн газрын 2003 оны 204-тогтоол Тайлангийн маягт батлах тухай /Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлан/	Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс;	Хот байгуулалтын тухай хуулийн 14.4.Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүсэд хот орчмын ой, ойн хамгаалах зурвас, амралт, сувилал, усан сан, цэцэрлэгт хүрээлэн, спортын цогцолбор, наран шарлагын газар зэрэг олон нийтийг хамрах амралт зугаалгын үйл		Амралт, рашаан сувилал-рекреацийн газар /4.4/	Газрыг шинэчлэн зохион байгуулах, төлөв байдлыг сайжруулах, инженерийн шугам сүлжээгээр хангах, архитектур төлөвлөлтийн зураг төсөл хийх, стандарт, норм дүрэмд нийцүүлэх төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх бүс	1. Газрын тухай хуулийн дагуу аль үндсэн ангиллын газар байршиж байгаагаас хамаарна 2. Газар ашиглалтын горим дэглэм тухайн газрын хуулиар тогтоосон дэглэмээр хязгаарлагдана Монгол улсын стандарт MNS 6034 : 2009: Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага

			ажиллагааг зохион байгуулахад зориулагдсан орон зайн задгай орчин, түүнчлэн байгалийн дархан цаазат болон онцгой хамгаалалттай газар нутгийг төлөвлөнө.				
Нийтийн эдэлбэр газар Газрын тухай хуулийн 12.2 Засгийн газрын 2003 оны 204-тогтоол Тайлангийн маягт батлах тухай /Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын тайлан/	Тусгай зориулалтын бүс	Тусгай зориулалтын бүс	Тусгай зориулалтын бүс	Тусгай зориулалтын бүс /5/	Нийтийн зориулалттай оршуулгын газар түүний эрүүл ахуйн бүс /5.1/	- Оршуулгын газрын эрүүл ахуйн бүс тогтоох, - Оршуулах зан үйлтэй холбоотой шашны барилга байгууламж барих - Оршуулгын газрын орчныг иргэдийг ёслол хүндэтгэл үйлдэх таатай орчин бүхий нийтээр ашиглах оршуулгын цогцолбор болгон тохижуулах, зураг төсөл боловсруулах - Хаагдсан оршуулгын газрыг хашаажуулан ойжуулах, цэцэрлэгжүүлэх зураг төсөл боловсруулах арга хэмжээ хэрэгжүүлэх	Ариун цэврийн тухай хуулийн 16.1.4.хөг хаягдал, бохир усны цэг, оршуулгын газарт ариун цэврийн шаардлага хангуулах, усны эх булагт ариун цэврийн хамгаалалтын бүсийн дэглэм сахиулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих. МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ 03.080.30 Оршуулгад хамаарах үйлчилгээ 4.3.2 Оршуулгын газрын хамгаалалтын бүсийг батлагдсан хил хязгаараас 300 метрээс багагүй хэмжээний зурвасыг эрх бүхий байгууллагаар тогтоолгосон байна. Эрүүл ахуйн шаардлага, нөхцөлийг хангасан чандарлах байгууламж байгуулж болно. - Оршоох зан үйлийн газрыг нийтээр үнэ төлбөргүй ашиглах /үйлчилгээний хураамж авна/
					Хог хаягдлын төвлөрсөн цэг түүний хамгаалалтын бүс /5.2/	- Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл - Ландфил, нөхөн сэргээлт хийх, ойжуулах, цэцэрлэгжүүлэх, хашиж хамгаалах	Хог хаягдлын тухай хуулийн 4.1.23.“хөг хаягдлын төвлөрсөн цэг” гэж хог хаягдал төвлөрүүлж, булшлах зөвшөөрөгдсөн газрыг; 17.4.8. Хамгаалалтын бүс нь орон сууц, олон нийтийн бүсээс 300 метрээс багагүй зайд; Хог хаягдал боловсруулах үйлдвэр эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангасан нөхцөлд хамгаалалтын бүсэд байршиж

							болно.
	Үйлдвэрийн газар	Хот байгуулалтын тухай хуулийн 13.1.2. Үйлдвэрлэлийн бүс; 14.2. Үйлдвэрлэлийн бүсэд үйлдвэр, нийтийн аж ахуй, агуулахын зориулалттай барилга байгууламж, тэдгээрийн үйл ажиллагааг хангах инженерийн болон зам тээврийн дэд бүтцийн барилга байгууламжийг төлөвлөнө.	Үйлдвэрлэлийн бүс	Үйлдвэрийн бүс /6/	Хүнд үйлдвэрийн бүс /6.1/	- Суурьшлын бүсээс тусгаарлах хамгаалалтын тусгай ногоон зурвас байгуулах - Газрыг шинэчлэн зохион байгуулах ГЗБ-н төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх - Төлөвлөлтийн зураг төслийн дагуу газар хөгжүүлэлт хийх	Газрын тухай хууль болон тухайн үйлдвэрлэлийн салбарын хууль тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журмаар зохицуулагдана
					Хөнгөн үйлдвэрийн бүс /6.2/	- Суурьшлын бүсээс тусгаарлах хамгаалалтын тусгай ногоон зурвас байгуулах - Газрыг шинэчлэн зохион байгуулах ГЗБ-н төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх - Төлөвлөлтийн зураг төслийн дагуу газар хөгжүүлэлт хийх	Хүнсний болон оёдол, сүлжмэл нэхмэл гэх мэт цогцолбор үйлдвэрүүд хамаарна. Салбарын стандарт, норм дүрмийн шаардлагад нийцүүлэн газрын байршил, хэмжээг тогтоож төлөвлөнө
					Тусгай нөхцөл бүхий үйлдвэрийн бүс /6.3/	- Суурьшлын бүсээс тусгаарлах хамгаалалтын тусгай ногоон зурвас байгуулах - Газрыг шинэчлэн зохион байгуулах ГЗБ-н төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх Төлөвлөлтийн зураг төслийн дагуу газар хөгжүүлэлт хийх	Био бэлдмэл, вакцины үйлдвэр /үйлдвэрийн ажиллагсдын орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хамт цогцолбор байдлаар байгуулах хил зааг бүхий эдэлбэр газартай байхаар төлөвлөх, хэрэгжүүлэх/ Нефт-хими, нүүрс-химийн үйлдвэр Тэсрэх дэлбэрэх бодисын үйлдвэр, агуулах Аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэр зэрэг тусгай нөхцөл бүхий үйлдвэрүүд
Уурхайн дэвсгэр газар			Уул уурхайн бүс /7/	Уул уурхайн олборлох үйлдвэрийн бүс /7.1/	- Бүлэг орд бүхий олон ашиглагчтай олборлох үйлдвэрийн бүсэд урьдчилсан ТЭЗҮ,	Газрын тухай хууль, ашигт малтмалын тухай хууль, түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль болон түүнд нийцүүлэн	

						газрын харилцаа, ГЗБ-ын нэгдсэн төлөвлөгөө зураг төсөл боловсруулж хэрэгжүүлэх - Олборлох үйлдвэрийн бүсийг салбар хоорондын ГЗБ хийж ажлын зураг төсөл боловсруулж хэрэгжүүлэх - Боловсруулах үйлдвэрийн цогцолборыг ТЭЗҮ-нд үндэслэн байршил, дэд бүтцийн сүлжээний хамт цогцоор төлөвлөх	гаргасан дүрэм журмаар зохицуулагдана
				Хот, тосгоны эдэлбэр газар дахь ХАА-н зориулалттай газар /8/	Хүлэмжийн аж ахуйн цогцолбор /8.1/	- Эдийн засгийн хувьд үр ашигтай байх байршлыг сонгох, ажлын зураг төсөл боловсруулж хэрэгжүүлэх - Хамгаалалтын ойн зурвас байгуулах Инженерийн нэгдсэн дэд бүтцийн зураг төсөл боловсруулж хэрэгжүүлэх	- Ажилчдын нийгэм ахуйн шаардлагыг хангах барилгын газар - Агуулахын аж ахуй, хиймэл хөрс, бордооны үйлдвэр, цехийн газар Шинжилгээний лабораторийн барилгын газрыг төлөвлөх
					Бусад ХАА-н цогцолборууд /8.2/	- Шувууны аж ахуйн цогцолбор - Үслэг, сорлог амьтны аж ахуй - Туулайн аж ахуй - Адууны аж ахуй /уралдаан спортын гэх мэт төрөлжсөн/ Мал эмнэлгийн үйлчилгээний төв, цэг	Хот суурины эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх
Хөдөө аж ахуйн газар		Бусад бүрэлдэхүүн хэсгийн төлөвлөгөөнд тусгагдсан				Газрын тухай хуулийн 11.1.Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна.	

Зам шугам сүлжээний газар						Газрын тухай хуулийн 13.1.Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, зам, замын зурвас газар, тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна.
Усны сан бүхий газар						Газрын тухай хуулийн 15.1.Усны сан бүхий газарт нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газар хамаарна.
Ойн сан бүхий газар						Газрын тухай хуулийн 14.1.Ойн сан бүхий газарт ой мод, загтай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас, ойг өсгөн үржүүлэхэд зориулсан, ой тэлэн ургах боломжийг хангахуйц газар хамаарна.
Улсын тусгай хэрэгцээний газар Газрын тухай хуулийн 16.3.Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас тусгай хэрэгцээнд авч болно	Улсын тусгай хамгаалалттай газар Газрын тухай хуулийн 16.1.1	Тусгай зориулалтын бүс	Тусгай зориулалтын бүс		Улсын тусгай хамгаалалттай газар	МУ-н үндсэн хууль болон Газрын тухай хууль, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журмаар зохицуулагдана. Тусдаа бүрэлдэхүүн хэсэг
	Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар Газрын тухай хуулийн 16.1.3				Улсын тусгай хэрэгцээний газар	Газрын тухай хуулийн 16.1-д заасан газар Тусдаа бүрэлдэхүүн хэсэг

ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР

Суурь ойлголт, нэр томъёоны гаргалгаа

Газрын тухай хуулийн 13.1-т “Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, зам, замын зурвас газар, тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна” гэж заасан байна.

Хүснэгт 8. Хуульд заасан суурь ойлголт

Дэд бүтцийн зориулалттай газар ашиглалт	Хот тосгон бусад суурины эдэлбэр дотор /Инженерийн дэд бүтцийн зориулалттай газар/	Хот тосгон бусад суурины эдэлбэрийн гадна
Цахилгаан, дулаан, хий, ус хангамж, ариутгах татуурга, зам, замын зурвас газар, тээвэр, холбоо, мэдээллийн станц, шугам сүлжээ байгуулах зориулалтаар олгогдсон газар	Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.10. “Инженерийн дэд бүтэц” гэж эрчим хүч, цэвэр, бохир усны болон зам, замын байгууламж, тээвэр, харилцаа холбооны шугам сүлжээ, барилга байгууламжийг Барилгын тухай хуулийн 4.1.33. “Инженерийн дэд бүтэц” гэж авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг; 4.1.35. “Инженерийн шугам сүлжээ” гэж ус хангамж, цахилгаан, дулаан, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, газрын тос болон төрөл бүрийн хий дамжуулах хоолой, харилцаа холбооны төвлөрсөн байгууламжийг;	Газрын тухай хуулийн 13. Зам, шугам сүлжээний газар Газрын тухай хуулийн 6.2. Хуульд өөрөөр заагаагүй бол дараах газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана 6.2.3. Зам, шугам сүлжээний газар

Газрын тухай хуулийн 12.1-т “Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаарна” гэж заасан бөгөөд ГНС-ын тайланд хотын эдэлбэрийн доторх агаарын тээврийн газар, зарим эрчим хүчний шугам сүлжээний газруудыг зам шугам сүлжээний ангиллын газарт хамруулсан байна.

Одоо өргөн баригдсан “Газрын ерөнхий хууль”-ийн 11.1-д мөн хот тосгон бусад суурины эдэлбэрийн гадна олгогдсон газар нь зам, шугам сүлжээний газрын ангилалд бүртгэгдэх зарчим хэвээр тусгагдсан байгаа тул цаашид газрын нэгдмэл сангийн ангиллыг шинэчлэн тогтоох хэрэгцээ хэвээр байна.

Хүснэгт 9. ГНС-н зам, шугам сүлжээний газрын дэд ангилал

ГНС-н дэд ангилал	Төрөл	Хуулийн үндэслэл
Авто замын газар	Улсын чанартай	Авто замын тухай хуулийн 4.1.1. “Авто зам” гэж тээврийн хэрэгсэл зорчиход зориулан барьсан замын байгууламж бүхий хатуу, хайрган хучилттай зам, гудамж, засаж, сайжруулсан болон ердийн хөрсөн замыг;
	Орон нутгийн чанартай	4.1.8. “Авто замын зурвас газар” гэж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, технологийн үйл ажиллагаа явуулах, цаашид авто замыг өргөтгөх зориулалтаар энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон газрыг;
	Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын зориулалттай	4.1.28. “Улсын чанартай авто зам” гэж Нийслэлийг аймгийн төвтэй, аймгийн төвийг хооронд нь болон хилийн боомттой холбосон авто замыг; 4.1.24. “орон нутгийн чанартай авто зам” гэж аймгийн нутаг дэвсгэр дэх хот, сум, суурин газар, фермерийн аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн баазыг хооронд нь холбосон болон тэдгээрийн доторх авто
	Авто тээврийн барилга, байгууламж, зогсоолын талбай	

		замыг; 4.1.9. “Аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто зам” гэж аж ахуйн нэгж, байгууллага өөрийн эзэмшлийн нутаг дэвсгэрт дотоодын хэрэгцээндээ зориулан барьсан авто замыг; 4.1.11. “Замын байгууламж” гэж бүх төрлийн гүүр, тавилан, гүүрэн гарц, унадаг дугуй болон явган зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход зориулсан зам, ус зайлуулах хоолой, шуудуу, хонгил, замын хөдөлгөөнийг зохицуулах болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зориулалттай төхөөрөмж, авто замын зурвас газарт байгаа төлбөр авах цэг, авто зогсоол болон бусад байгууламжийг;
Төмөр замын газар	Төмөр замын далангийн талбай, хамгаалалтын зурвас газар	Төмөр замын тээврийн тухай хуулийн 3.1.1. “Төмөр замын объект” гэж төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зурвас газар, суурь бүтэц, дагнасан хэрэглээний зам, талбай, хөдлөх бүрэлдэхүүн болон бусад тоног төхөөрөмж, эд хөрөнгийг; 3.1.3. “Төмөр замын шугам” гэж төмөр замын өртөө хоорондын зам болон өртөөн дэх түүний шууд үргэлжлэлийг;
	Өртөө, зөрлөгийн барилга, байгууламжийн талбай	3.1.2. “суурь бүтэц” гэж төмөр замын шугамын дээд, доод бүтэц болон гүүр, хоолой зэрэг инженерийн байгууламж, өртөө, зөрлөг, галт тэрэгний хөдөлгөөний хэвийн үйл ажиллагааг хангах эрчим хүч, усан хангамж, дохиолол холбоо, мэдээллийн барилга байгууламж, гарам, хориг хашаа зэрэг техник технологийн иж бүрдлийг;
Агаарын тээврийн газар	Нислэгийн аюулгүй байдлыг хамгаалах бүсийн газар	Иргэний нисэхийн тухай хууль 3.1.7. “аэродром орчмын аюулгүйн бүс” гэж аэродромыг байгуулахдаа нислэгийн аюулгүй ажиллагааг хангах зайлшгүй шаардлагыг үндэслэн тогтоосон тодорхой хэмжээний хуурай газар, усан гадаргуу, орон зай;
	Барилга, байгууламж, төхөөрөмжийн газар	Иргэний нисэхийн тухай хууль 3.1.18. “нисэх буудал” гэж аэродром, агаарын тээврийн үйлчилгээний барилга, байгууламжийн цогцолбор 3.1.6. “аэродром” гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулж тусгайлан тоноглогсон газар болон усан гадаргуу;
Шугам сүлжээний газар	Холбооны шугам, холбоо мэдээлэл хүлээн авах станцын эзлэх талбай	Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.1. “шугам” гэж мэдээлэл нэвтрүүлэх, дамжуулах, хүлээн авах зорилгоор байгуулсан аливаа дамжуулагч орчин /утас, радио долгион, орон зай зэрэг/, тэдгээрийг хамгаалахад хэрэглэдэг тусгаарлагч, сувагчлал, багана, цамхаг, байр, талбай болон бусад зүйлсийн цогцолборыг;
	Эрчим хүчний шугам, станцын эзлэх талбай	Эрчим хүчний тухай хуулийн 3.1.4. “Эрчим хүчний эх үүсвэр” гэж эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа байгууламжийг; 3.1.5. “нэгдсэн сүлжээ” гэж цахилгаан хангамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хоорондоо холбогдсон эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээний нэгдлийг; 3.1.7. “цахилгаан дамжуулах сүлжээ” гэж нэгдсэн сүлжээ үүсгэж байгаа цахилгаан дамжуулах зориулалт бүхий 110 кв, түүнээс дээш хүчдэлийн шугам, дэд станц, түүнчлэн энэ сүлжээнд холбогдсон, эсхүл техник, технологийн хувьд энэ сүлжээнд хамрагдах шаардлагатай бусад хүчдэлийн шугам, дэд станцыг; 3.1.8. “цахилгаан түгээх сүлжээ” гэж эх үүсвэрээс шууд холбогдсон болон цахилгаан дамжуулах сүлжээний дэд станцаас хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх цахилгаан түгээх зориулалт бүхий 110кВ, түүнээс доо шугам, дэд станцыг;
		3.1.9. “эрчим хүчний барилга байгууламж” гэж эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам, дэд станц болон технологийн зориулалттай бусад байгууламжийг;

	Ус дулаан дамжуулах хоолой эзлэх талбай	Эрчим хүчний тухай хуулийн 3.1.13.“дулаан дамжуулах сүлжээ” гэж эрчим хүчний эх үүсвэрээс дулаан хуваарилах төв хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийг; 3.1.14.“дулаан түгээх сүлжээ” гэж дулаан хуваарилах төв, түүнээс хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх дулааны шугам, тоног төхөөрөмжийг; 3.1.25.“цөмийн эрчим хүчний эх үүсвэр” гэж цөмийн эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж эрчим хүч үйлдвэрлэж байгаа байгууламжийг; Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.3.“ариутгах татуурга” гэж хэрэглээнээс гарсан бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламж, бохир усны цооногийг; 3.1.5.“шугам сүлжээ” гэж цэвэр ус дамжуулах, түгээх, хэрэглээнээс гарсан бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах байгууламжийг; 3.1.5.“шугам сүлжээ” гэж цэвэр ус дамжуулах, түгээх, хэрэглээнээс гарсан бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах байгууламжийг; 3. 1.6.“цэвэр ус дамжуулах шугам” гэж ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжаас ус дамжуулах төв болон удирдах зангилааны тоолуурын өмнөх хаалт хүртэлх шугам сүлжээг; 3.1.7.“цэвэр ус түгээх шугам” гэж ус дамжуулах төв болон удирдах зангилааны тоолуурын өмнөх хаалтаас хэрэглэгчийн тоолуурын өмнөх хаалт хүртэлх шугам сүлжээг;
	Ус шахах, өргөх байгууламжийн доорх газар	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 3.1.4.“ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж” гэж гүний болон гадаргын ус ашиглан ус олборлох, цэвэршүүлэх, цуглуулах шугам сүлжээ, усан сан, шахуургын станцыг;
	Үерээс хамгаалах далан, сувгийн эзлэх талбай	Усны тухай хуулийн 3.1.13.“усны барилга байгууламж” гэж усны түрэлт, урсцыг тохируулах, ус хуримтлуулах, хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын доорх ус олборлох, усны үер, гамшгаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга байгууламжийг;
Усан тээврийн газар		Усан замын тээврийн тухай хуулийн 3.1.11.“зогсоол” гэж зорчигчдыг буулгах, суулгах, ачаа ачих, буулгахад зориулагдсан, гэрэлтүүлэг, аврах хэрэгсэл зэргээр бүрэн хангагдсан эрэг дээрх байгууламжийг; 3.1.13.“усан замын төв буудал” гэж энэ хуулийн 3.1.11-д зааснаас гадна усан замын тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх, шатахуун түгээх, зорчигчийн танхим, ачаа, тээш хадгалах агуулах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эмчилгээний, уснаас эрэн хайх, аврах бүлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хадгалах хэсэг болон бусад шаардлагатай өрөө бүхий цахилгаан эрчим хүчээр хангагдсан усан замын тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоолыг;

Хүснэгт 10. Төлөвлөлтийн баримт бичгүүдийн төрлүүд, бүрэлдэхүүн хэсэг /хуулийн тодорхойлолт/

Ажлын нэр	Хуулийн ойлголт	Нэмэлт тайлбар
Зураг төсөл	Барилгын тухай хуулийн 4.1.30.“Зураг төсөл” гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг,	ГЗБЕТ-ний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд барилга байгууламжийн трассын схемийг төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шатанд

	барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;	трассын дагуу судалгаа хийсний үндсэн дээр нарийвчилсан трассыг тогтооно. Трасс сонголтыг хийсний дараа зураг төсөл
Зураг төсөл боловсруулах үнэ	Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 108 дугаар тушаалын хавсралт “ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ЖИШИГ ҮНЭ” 2.1.Зураг төслийн ажлын жишиг үнэ нь нутаг дэвсгэр, хот тосгоны эдэлбэр газрын хэмжээ, хүн амын тоо гэсэн үндсэн үзүүлэлтээр тодорхойлж, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах жишиг үнийг интерполяцийн аргаар тооцсон, барилга байгууламжийн нэгж үндсэн үзүүлэлтээр /талбай, уртын хэмжээ, хүчин чадал/ тодорхойлогдсон үнийг хэлнэ. 2.2.“Зураг төсөл боловсруулах үнэ” нь зураг төслийн ажлын жишиг үнэ, нэмэгдэл зардлын нийлбэрээр тодорхойлогдоно.	боловсруулах бөгөөд зураг төслийн ажлын зардлыг жишиг үнээр тооцож ГЗБЕТ-ний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгав. Хот тосгон бусад суурины газар доторх төлөвлөж буй инженерийн дэд бүтэц-зам тээврийн бүсийн төлөвлөлтийг Хотын хөгжлийн төлөвлөгөөгөөр нарийвчлан тогтоох нь зүйтэй

ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

Суурь ойлголт

Монгол улсын газрын нэгдмэл сангийн үндсэн 6 ангиллын нэг нь “Ойн сангийн газар” бөгөөд Газрын тухай хуулийн 14.1-т Ойн сан бүхий газарт ой мод, загтай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас болон ойг өсгөн үржүүлэхэд зориулсан газар, мөн ой тэлэн ургах боломжийг хангахуйц ойн захын тодорхой хэсэг газар хамаарна гэж заасан байна.

Хүснэгт 11. Ойн сангийн тухай ойлголт

	Хуулийн ойлголт
Ой	3.1.1 Мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог бүхий орчныг
Ойн сан	3.1.2 Мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчин болон ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй болон ойн тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчныг
Ойн нөөц	3.1.3 Ойг талбай, ургаа модны эзлэхүүнээр нь илэрхийлснийг
Ашиглах нөөц	3.1.4 Ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хангах нөхцөлтэйгөөр тодорхой хугацаанд авч ашиглаж болох модны дээд хэмжээг
Эзэмшлийн ой	3.1.5. Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд хариуцан хамгаалж, эзэмшиж, ашиглаж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг
Ойн менежментийн төлөвлөгөө	3.1.6 Тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг;

Хүснэгт 12. Нэр томьёоны гаргалгаа

Нэр томьёо	Ойн тухай хуулийн тайлбар
Ой	3.1.1."ой" гэж мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг
Ойн сан	3.1.2."ойн сан" гэж энэ хуулийн 3.1.1-д заасан ой, ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй болон ойн тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчныг
Ойн нөөц	3.1.3."ойн нөөц" гэж ойг талбай, ургаа модны эзлэхүүнээр нь илэрхийлснийг
Ойн экологи-эдийн засгийн үнэлгээ	Ойн тухай хуулийн 3.1.7. Нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний экологи- эдийн засгийн үр өгөөжийг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг
Ойн нөхөрлөл	3.1.8 Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-д заасны дагуу зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллагыг
Ойг хамгаалах	3.1.9. Ой, хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин зэрэг ойн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, ойн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр ойн нөөцийн даацад тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавьж гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг
Ойг ашиглах	3.1.10. Ойн сангаас зохих журам, заавар, стандартын дагуу ойн баялгийн даацад тохируулан мод, ойн дагалт баялгийг бэлтгэх үйл ажиллагааг
Ойн баялаг	3.1.11. Ойн модны нөөц, түүний дагалт баялгийн нөөцийг
Ойн дагалт баялаг	3.1.12. Ойн сангийн газарт ургадаг жимс, жимсгэнэ, мөөг, самар, эмийн болон хүнс, тэжээл, техникийн ургамал, модны холтос, үйс, хусны шүүс, давирхай, ойн хөвд, хөвхөн зэрэг ойгоос авч ашиглаж байгаа аливаа баялгийн нөөцийг
Ойн тооллого,ойн зохион байгуулалт	3.1.13. Ойн сангийн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүн, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг тогтоох, хүлэмжийн хийн шингээлтийг тооцох, биомассын судалгаа хийх, ойн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлсон үйл ажиллагааг;
Ой үржүүлэг	3.1.14."Ой үржүүлэг" гэж урьд өмнө нь ой байгаагүй газарт таримал ой ургуулахыг

Ойн цэвэрлэгээ	3.1.15. Ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлэх замаар ойг хамгаалах, ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг
Ойн санд үзүүлэх хортой нөлөөлөл	3.1.16. Аж ахуйн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад ойн санд бүрдүүлэгч хүчин зүйлийн даац чадавхад хохирол учруулсан, ойг бохирдуулж, улмаар ойн төлөв байдлыг доройтуулсан бүхий л сөрөг үйлдлийг

Хүснэгт 13. Үндсэн нэр томьёо, салбарын стандарт, бусад баримт бичигт заасан үндэслэл

Нэр томьёо	Тайлбар /Ойн нэр томьёоны товч тайлбар толь, Ч.Доржсүрэн, Ч.Дугаржав, Ц.Чулуунбаатар, 2017 он/
Мод	Титэм бүхий гол иштэй, олон наст модлог ургамал
Байгалийн ой	Байгалийн аясаар сэргэн ургасан уугуул модноос бүрдсэн ой.
Тармаг ой	Сийрэг модтой, 0.3-аас доош өтгөрөлтэй ойн талбай
Ойн өтгөрөл	Ургаж байгаа талбайнхаа гадаргын орон зайг модод хэр зэрэг ашиглаж байгааг модны ишний хөндлөн огтлолын талбайн нийлбэрээр илэрхийлэн харуулсан үзүүлэлт. Өтгөрлийг үнэмлэхүй ба харьцангуй гэж ялгадаг. Үнэмлэхүй өтгөрөл гэдэг нь нэгж талбайд ногдох модны хөндлөн огтлолын нийлбэр бөгөөд м2/га гэсэн үнэмлэхүй нэгжээр илэрхийлэгдэнэ. Харьцангуй өтгөрөл нь тухайн ойн үнэмлэхүй өтгөрлийг 1.0 өтгөрөлтэй жишиг ойн үнэмлэхүй өтгөрөлд харьцуулж, аравны нэгжээр илэрхийлсэн үзүүлэлт.
Ойн талбай	Ойн модоор бүрхэгдсэн болон бүрхэгдээгүй боловч урьд нь ой мод байсан, цаашид ой ургуулах зориулалт бүхий талбай /Газар/

УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР

Суурь ойлголт

Газрын тухай хуулийн 10 дугаар зүйлд түүн дотроо 10.1.5-д усны сан бүхий газрыг газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал гэж тодорхойлсон байдаг.

Усны сан бүхий газарт хамгаалалтын бүсийн газрыг оруулдаггүй байсан бөгөөд 2012 онд батлагдсан Усны тухай хуулийн 3.1.4. "Усны сан бүхий газар" гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг гэж заасан тул 2019 онд Газрын тухай хуулийн 15.1 заалтад өөрчлөлт орж усны сан бүхий хамгаалалтын бүсийг хамруулахаар тусгасан байна.

Хүснэгт 14. Усны сан бүхий газрын тухай ойлголт

	Хуулийн ойлголт	Усны сан бүхий газарт тооцох эсэх
Усны сан бүхий газар	Усны тухай хуулийн 3.1.4. "Усны сан бүхий газар" гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг	
Усны сав газар	Усны тухай хуулийн 3.1.3. "Усны сав газар" гэж гадаргын ус хурах талбай болон газрын доорх усны нөөцийг бүрдүүлэх тэжээгдлийн муж, тархалтын талбайг хамарсан орон зайг;	Хуулийн заалтад ус хурах талбай, тэжээгдлийн муж зэрэг талбайг заагаагүй тул усны сан бүхий газарт тооцогдохгүй.
Гол, мөрний урсац бүрэлдэх эх	Усны тухай хуулийн 3.1.5. "гол, мөрний урсац бүрэлдэх эх" гэж гадаргын урсцын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс, сав газрын эхийг;	Хуулийн заалтад урсац бүрэлдэх эхийг тусгайлан заагаагүй боловч Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 2.3.1. гол мөрний урсац бүрэлдэх эх хэсэгт түүний эргээс усны хагалбарын хил хүртэлх зайд онцгой хамгаалалтын бүс тогтоохоор заасан тул усны сан бүхий газарт орохоор байна.
Усны эх үүсвэрийн газар	3.1.6. "усны эх үүсвэр" гэж ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа усны нөөц болон гол мөрний урсац бүрэлдэх эхийг;	Хуулийн заалтад усан хангамжийн эх үүсвэрийн газрыг тусгайлан заагаагүй гэвч Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын
Ус хангамжийн эх үүсвэр	3.1.15. "ус хангамжийн эх үүсвэр" гэж худаг, татах, цуглуулах, цэвэршүүлэх байгууламж, түгээх зориулалт бүхий усны барилга байгууламжийг;	2.3. Онцгой хамгаалалтын бүсийг дараах байдлаар тогтооно. 2.3.5. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориголлын бүсэд гэж заасан тул тус бүс нь усны сан бүхий газарт тооцогдохгоор байна. 3.13. Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориголлын бүсийг тогтооно гэсэн тул тухайн барилга байгууламжаас 100м газрын усны сан бүхий газарт тооцохоор байна.
Усны нөөц	Усны тухай хуулийн 3.1.1. "усны нөөц" гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг;	Усны сан бүхий газарт нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг гэж заасан тул газрын доорх усны нөөц бүхий газар бүгд тооцогдохгүй.
Усны барилга байгууламж	Усны тухай хуулийн 3.1.13. "Усны барилга байгууламж" гэж усны түрэлт, урсцыг тохируулах, ус хуримтлуулах, хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын	Инженерийн хийц бүхий барилга байгууламжийн газрыг хуульд тусгайлан заагаагүй. Гадаргын ус дээр байгаа байгууламж нь усны сан бүхий газарт хамаарна. Гүний ус ашиглах зориулалттай бусад байгууламжууд усны сан бүхий газарт хамаарахгүй. /Үүнд: бэлчээр дэх худаг, хот

	доорх ус олборлох, усны үер, гамшгаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга байгууламжийг;	суурин газрын ус түгээх худгууд хамаарна/
Гол мөрний татам	3.1.34."гол мөрний татам" гэж голын голдирлын эргээс эхний дэнж хүртэлх нугын зурвас бүсийг	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 2.3.2.гол мөрөн, горхи, булаг, шандын эргээс 50 метрээс доошгүй зайд буюу түүнээс өргөн, намаг бүхий татамтай тохиолдолд нийт татмын хэмжээгээр өргөсгөж гэж заасан тул голын татам усны сан бүхий газарт тооцогдоно.

Хүснэгт 15. Нэр томьёоны гаргалгаа

Нэр томьёо	Усны тухай хуулийн тайлбар
Нуур	Хуурай газраар хүрээлэгдсэн их хэмжээний тогтмол ус /Монгол хэлний их тайлбар толь/
Цөөрөм	Нуурыг бодвол бага хэмжээтэй, ихэвчлэн хур тунадасны уснаас тогтсон урсгалгүй усан сан /Монгол хэлний их тайлбар толь/
Тойром	Хур элбэгтэй цагт нуур болж, ус бороо ховор цагт шавар шалбааг болох буюу бүр хатаж хуурайшдаг хужирлаг шороо бүхий халцгай, хонхор газар /Монгол хэлний их тайлбар толь/
Гол	Газрын доорх болон хөрсний уснаас эх авч өөрийн голдирол саваар байнга урсах байгалийн урсгал ус /Монгол хэлний их тайлбар толь/
Мөрөн	Голоос том, далай тэнгист цутгадаг урсгал их ус /Монгол хэлний их тайлбар толь/
Горхи	Байгалийн бага хэмжээний урсгал ус /Монгол хэлний их тайлбар толь/
Булаг	Газар дороос ундран гарах ус /Монгол хэлний их тайлбар толь/
Шанд	Говь газрын бяцхан булаг /Монгол хэлний их тайлбар толь/
Усан сан	Усны тухай хуулийн 3.1.12."усан сан" гэж усны нөөцийг хуримтлуулах, ашиглах зориулалтаар бий болгосон хиймэл нуур, хөв, цөөрмийг;
Рашаан	Усны тухай хуулийн 3.1.7."рашаан" гэж физикийн болон химийн өвөрмөц шинж чанар бүхий эмчилгээний ач холбогдолтой байгалийн ус, шаврыг;
Намаг	Зүлэг шавартай нойтон, чийгтэй бамбалзуур газар, ургамлын өвөрмөц бүрхэвчтэй, ихэнхдээ хүлэр агуулсан, хэт чийгшилтэй хуурай газрын хэсэг /Монгол хэлний их тайлбар толь/
Мөстөл	Мөсөөр бүрхмэл газар /Монгол хэлний их тайлбар толь/
Мөсөн гол	Өндөр уулын оройгоос уулын жалга завсар даган буусан мөс /Монгол хэлний их тайлбар толь/
Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	Усны тухай хуулийн 3.1.9."Онцгой болон энгийн хамгаалалтын бүс" гэдэгт усны сан бүхий газар, усны эх үүсвэр, рашааны ордыг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг;
Ус ашиглах боломжит нөөц	Усны тухай хуулийн 3.1.2."Ашиглах боломжит нөөц" гэж усны сав газрын экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр тодорхой хугацаанд ашиглаж болох усны нөөцийн хэмжээг;

УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР

Суурь ойлголт

Улсын тусгай хэрэгцээний газар газар нь газрын тухай хуулийн 16.1-16-д заасан газрууд хамаарах ба улсын тусгай хамгаалалттай газраас гадна “Тусгай хэрэгцээний газар”-ууд байдаг. Тусгай хэрэгцээний газар нь нийт 16 төрөлтэй. Үүнд:

Хүснэгт 16. Улсын тусгай хэрэгцээний газрууд

Газрын тухай хуулийн заалт	Ангиллын нэр	Нэмэлт мэдээлэл, тайлбар, аймгийн нутаг дэвсгэрт байдаг эсэх
16.1.1	Улсын тусгай хамгаалалттай газар	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3.1-т 1/ Дархан цаазат газар; /ДЦГ/ 2/ Байгалийн цогцолборт газар /БЦГ/ 3/ Байгалийн нөөц газар; /БНГ/ 4/ Дурсгалт газар /ДГ/ гэж ангилна. 2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч болно. Дорнод аймгийн нутаг дэвсгэрт Дорнод Монголын, Монгол дагуурын А”болон”Б” хэсэг, Нөмрөг ДЦГ-т, Баянцагааны тал, Угтам уул, Онон балж голын сав газар, Тосон хулстай, Яхь нуур, Мэнэнгийн сав газар, Халх таван уул, Хөх нуур, Ташгай таван нуур, Жаран тогооны талийн А болон Б, Баяндун уул байгалийн нөөц газар гэсэн ангиллаар улсын тусгай хамгаалалттай газарт хамаарч байна.
16.1.2	Улсын хилийн зурвас газар	Монгол улсын хилийн тухай хуулийн 26.1.Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ. Дорнод аймгийн нутаг дэвсгэрт Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Чойбалсан, Баянтүмэн, Матад, Халхгол сумууд хилийн зурвас газартай байна.
16.1.3	Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	Монгол улсын батлан хамгаалах тухай хуулийн 3.1.1.“батлан хамгаалах” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улсын бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, мэдээллийн болон цэргийн нэгдмэл арга хэмжээг; Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3.4. Үндэсний аюулгүй байдал нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 3.4.1. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал; 3.4.2. Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал; 3.4.3. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал; 3.4.4. Эдийн засгийн аюулгүй байдал; 3.4.5. Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал; 3.4.6. Мэдээллийн аюулгүй байдал; 3.4.7. Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал; 3.4.8. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал; 3.4.9. Экологийн аюулгүй байдал. 3.4.10. Хүнсний аюулгүй байдал гэж заасан бөгөөд Улсын их хурал тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, заагийг тогтоох эрхтэй.
		Аймгийн нутаг дэвсгэрт тодорхой хэмжээний газрууд байдаг. /нууцлалтай/
16.1.4	Гадаад улсын	Дипломат албаны тухай хуулийн

	дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар	6.1. Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газарт Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар тус тус хамаарна гэж заасан бөгөөд гадаад улсаас Монгол улсад суугаа дээр дурдсан байгууллагуудыг мөн адилтган тооцох нь зүйтэй бөгөөд тэдгээр байгууллагуудад зөвшөөрсөн байршлуудад олгосон газруудыг ойлгох ба Улсын их хурал тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, заагийг тогтоох эрхтэй ГНС-н тайлангаар 2 га газар бүртгэлтэй байна.
16.1.5	Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалын талбай	Газрын тухай хуулийн 18.1.2-т заасны дагуу Засгийн газар уг ангиллаар тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, хил заагийг батлах эрхтэй ГНС-н тайлангаар 6025.97 га газар бүртгэлтэй байна.
16.1.6	Аймаг дундын отрын бэлчээр	Газрын тухай хуулийн 18.1.2-т заасны дагуу Засгийн газар уг ангиллаар тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, хил заагийг батлах эрхтэй Аймгийн хэмжээнд 124400 га газар бүртгэлтэй байна
16.1.7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	Газрын тухай хуулийн 18.1.2-т заасны дагуу Засгийн газар уг ангиллаар тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, хил заагийг батлах эрхтэй.
16.1.8	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	Газрын тухай хуулийн 18.1.2-т заасны дагуу Засгийн газар уг ангиллаар тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, хил заагийг батлах эрхтэй ГНС-н тайлангаар 65070.92 га газар бүртгэлтэй байна.
16.1.9	Чөлөөт бүсийн газар	Газрын тухай хуулийн 17.1.3-т заасны дагуу Улсын их хурал тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, заагийг тогтоох эрхтэй ГНС-н тайлангаар 500000 га газар бүртгэлтэй байна
16.1.11	Бичил уурхайн зориулалтаар олгосон газар	Газрын тухай хуулийн 16.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэг энэ хуулийн 16.1.1, 16.1.6, 16.1.7, 16.1.11-д заасан зориулалтаар өөрийн эрх хэмжээнд нийцүүлэн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч болно гэж заасан бөгөөд тусгай хэрэгцээнд авах газрын байршил хил заагийг ямар шатны байгууллага тогтоох талаар тусгайлан заагаагүй байна. 2020 оны ГНС-ийн тайлангаар 26.2 га газар бүртгэлтэй байна.
1.12	Хилийн боомтын бүс	Монгол улсын хилийн тухай хуулийн 3.1.12. “Хилийн боомт” гэж улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зориулалтаар төхөөрөмжилсөн, тусгайлан тогтоосон газрыг; 27.1. Хилийн боомт нь агаарын замын, төмөр замын, авто замын гэсэн төрөлтэй, байнгын, түр гэсэн горимтой, олон улсын, хоёр талын гэсэн зэрэглэлтэй байна гэж заасан ба Улсын их хурал тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, заагийг тогтоох эрхтэй.
16.1.13	Үндэсний хэмжээний томоохон бүтээн	Газрын тухай хуулийн 18.1.2-т заасны дагуу Засгийн газар уг ангиллаар тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, хил заагийг батлах эрхтэй

	байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	ГНС-н тайлангаар тус ангиллын газар одоогоор байхгүй байна.
16.1.14	Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	Газрын тухай хуулийн 18.1.2-т заасны дагуу Засгийн газар уг ангиллаар тусгай хэрэгцээнд авах, гаргах, хэмжээ, хил заагийг батлах эрхтэй Хог хаягдлын тухай хуулийн 25-р зүйлд тавигдах шаардлагыг тодорхойлсон байдаг. ГНС-н тайлангаар тус ангиллын газар одоогоор байхгүй байна.

Хүснэгт 17. Улсын тусгай хамгаалалттай газрын бүсийн дэглэм

Төрөл	Хуулийн заалт
	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай ууль 8 дугаар зүйл. Дархан цаазат газрын бүс Дархан цаазат газрыг байгалийн хэв шинж, төлөв байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан дараах бүсэд хуваана: 1/ онгон бүс; 2/ хамгаалалтын бүс; 3/ хязгаарлалтын бүс.
Дархан цаазат газар	9 дүгээр зүйл. Онгон бүсийн дэглэм 2. Онгон бүсэд байгалийн төлөв байдлыг нь хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулж болох бөгөөд үүнээс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. 10 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн дэглэм Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 9 дүгээр зүйлд зааснаас гадна ургамал, амьтны аймгийн өсөж үржих нөхцөлийг хангах, гамшгийн хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлнэ. 11 дүгээр зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм Хязгаарлалтын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгөөр дараах үйл ажиллагаа явуулж болно: 1/ энэ хуулийн 9,10 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа; 2/ хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх; 3/ ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх; 4/ ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах; 5/ рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ашиглах; 6/ байгалийн аялал, жуулчлалыг тогтоосон зам, чиглэлээр зохих журмын дагуу зохион байгуулах; 7/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах; 8/ зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол бүтээл туурвихад ашиглах; 9/ уул, овоо тахиx, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх; 10/ нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах 12 дугаар зүйл. Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагаа Дархан цаазат газарт энэ хуулийн 10,11 дүгээр зүйлд зааснаас өөр зориулалтаар дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 1/ газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга чулуу авах, мод, зэгс, шагшуурга бэлтгэх, хязгаарлалтын бүсээс бусад газарт зам тавих зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх; 2/ байгалийн дагалт баялаг, эмийн, хүнсний болон техникийн зориулалттай ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх; 3/ энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 4-т зааснаас өөр зориулалтаар ан амьтан агнах, барих, үргээх, тэдгээрийн үүр, ичээ, нүх, ноохойг хөндөх, эвдэж сүйтгэх; 4/ хортон шавж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс сэргийлэх арга хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөөлөх арга, техник, бодис хэрэглэх; 5/ энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 7-д зааснаас өөр барилга байгууламж барих; 6/ хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулах;

	7/ тухайн газрын хамгаалалтын захиргааны зөвшөөрөлгүйгээр нохой дагуулж, буу авч явах; 8/ аргагүйгээс бусад тохиолдолд тухайн газрын хамгаалалтын захиргаанаас урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгөөр буулт хийх, хэт нам өндрөөр нислэг үйлдэх; 9/ өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх; 10/ нуур, мөрөн, гол горхи, булаг, шанд зэрэг ил задгай усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах; 11/ хууль тогтоомж болон хамгаалалтын горимоор хориглосон байгаль орчинд сөрөг нөлөөлөх бусад үйл ажиллагаа явуулах.
Байгалийн цогцолбор газар	14 дүгээр зүйл. Байгалийн цогцолборт газрын бүс Байгалийн цогцолборт газрыг байгалийн хэв шинж, ургамал, амьтны аймгийн байршил, түүх, соёлын дурсгалыг нь хадгалах шаардлага, аялал, жуулчлал хөгжүүлэх нөхцөл зэргийг харгалзан дараах бүсэд хуваана: 1/ онцгой бүс; 2/ аялал, жуулчлалын бүс; 3/ хязгаарлалтын бүс. 15 дугаар зүйл. Онцгой бүсийн дэглэм Онцгой бүсэд байгалийн унаган төрхийг нь хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсөж үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ авна. 16 дугаар зүйл. Аялал, жуулчлалын бүсийн дэглэм Аялал, жуулчлалын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгөөр дараах үйл ажиллагаа явуулж болно: 1/ энэ хуулийн 11,15 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа явуулах; 2/ зөвшөөрөгдсөн газар загас барих. 17 дугаар зүйл. Хязгаарлалтын бүсийн дэглэм Хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулж болно: 1/ энэ хуулийн 11,15,16 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа; 2/ уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх; 3/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих; 4/ батлагдсан зураг төсөл, зохих журмын дагуу зам тавих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах; 5/ биеийн тамир, нийтийн арга хэмжээнд шаардагдах талбайг засаж тохижуулах; 6/ тухайн нутаг дэвсгэр дэх сууриныг экологийн магадлан шинжилгээ хийж баталсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх. 18 дугаар зүйл. Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагаа Байгалийн цогцолборт газарт энэ хуулийн 15,16,17 дугаар зүйлд зааснаас өөр зориулалтаар дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 1/ энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1-8, 11-т заасан үйл ажиллагаа явуулах; 2/ онцгой бүсэд энэ хуулийн 12 дугаар зүйлийн 9,10-т заасан үйл ажиллагаа явуулах; 3/ батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж суурингийн нутаг дэвсгэрийг тэлэх, барилга байгууламж барих.
Байгалийн нөөц газар	19 дүгээр зүйл Байгалийн нөөц газар Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ. 20 дугаар зүйл : Нөөц газрын төрөл : 1/ Байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий байгалийн иж бүрдлийн нөөц газар 2/ Ховор ховордсон ургамал, амьтныг хамгаалах, тэдгээрийн нөхөн үржих нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий биологийн нөөц газар 3/ Эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь

	хадгалах зорилго бүхий байгалийн түүхэн олдворын нөөц газар 4/ Газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий геологийн нөөц газар 5/ Мөрөн, гол, усны эх үүсвэрийг хамгаалах зорилго бүхий усны нөөц газар 21 дүгээр зүйл. Байгалийн нөөц газрын дэглэм 1. Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр аж ахуй эрхэлж болно. 2. Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, мал аж ахуй эрхлэгч малчин өрхөд өвөлжөө, хаваржааны газар олгох, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
Дурсгалт газар	22 дугаар зүйл. Дурсгалт газар Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ. 23 дугаар зүйл. Дурсгалт газрын төрөл 1. Дурсгалт газрыг дараах төрөлд хуваана: 1/ байгалийн дурсгалт газар; 2/ түүх, соёлын дурсгалт газар; 3/дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газар. 2. Байгалийн дурсгалт газарт өвөрмөц тогтоц, илэрц бүхий газар, эртний ургамал, амьтны чулуужсан үлдэгдэл, давхаргазүйн тулгуур зүсэлт зэрэг эрдэс чулуулгийн ховор олдвор,хүрхрээ, хясаа, хавцал, агуй, хад цохио, явар, цонж, төгөл мод, рашаан булаг, баянбүрд, элсэн манхан, солир, солирын цар, өрх, галт уулын тогоо зэргийг хамааруулж болно. 3. Түүх, соёлын дурсгалт газарт эртний хүний оромж, отог, сууц, агуй, сүг зураг, хадны бичээс, буган ба хүн чулуун хөшөө, булш бунхан, эртний хот, суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, суваг шуудуу, далан, эртний зэр зэвсэг хийж байсан орд, уламжлалт зан үйлтэй холбоотой уул, овоо, тахилга бүхий болон түүхэн чухал үйл явдал болсон газар зэргийг хамааруулж болно. 24 дүгээр зүйл. Дурсгалт газрын дэглэм 1. Дурсгал газарт хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулан өгөх зэргээр хамгаалалтын арга хэмжээ авна. 2. Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс О,1- 3,О км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. 3.Дэлхийн болон Үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын дэглэмийг хуулиар тогтооно.

Хүснэгт 18. Түүх соёлын дурсгалт газар

Төрөл	Хуулийн заалт
Түүх соёлын дурсгалт газар	СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ хууль 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3.1 Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. 3.1.1 “Соёлын өв” гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өвийг 3.1.2 “Соёлын биет өв” гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх биетээр оршин байгаа дурсгалыг 3.1.3. “Түүх, соёлын үл хөдлөх дурсгал” гэж унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ, цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дангаар болон цогцолбор байдлаар орших дурсгалыг 38.1. Соёлын өвд хохирол учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хориглоно: 38.1.1. түүх, соёлын дурсгалт газар түүний орчны бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл явуулах; 38.1.2. палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох; 38.1.3. хуульд зааснаас бусад тохиолдолд нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөр байгууллага, орчинд шилжүүлэн хадгалах, зөөж тээвэрлэх, хөдөлгөх; 38.1.4. улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалд зар сурталчилгааны самбар, бичиг хадах, анхны хэлбэр төрх, хийц, бүтээцийг өөрчлөх. 42.4. Соёлын өвийн дурсгалт газрыг дараах бүсэд хуваана: 42.4.1. хамгаалалтын бүс; 42.4.2. орчны бүс. 42.6. Хамгаалалтын болон орчны бүсэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр байгаль, соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж болно. 43.1. Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 43.1.1. онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд нисэх онгоц буулгах; 43.1.2. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах; 43.1.3. мод, элс, хайрга, чулуу авах зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх; 43.1.4. хот суурин, цахилгаан станц байгуулах; 43.1.5. тэсэлгээ хийх; 43.1.6. шинээр барилга байгууламж барих. 44.1. Орчны бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 44.1.1. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах; 44.1.2. хот суурин, цахилгаан станц байгуулах; 44.1.3. тэсэлгээ хийх. 45.3. Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 45.3.1. газар, түүний хэвлийг хөндөх; 45.3.2. мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй мод бут, төрөл бүрийн ургамал тарих; 45.3.3. гэр, сууц, барилга, байгууламж барих; 45.3.4. мал бэлчээх; 45.3.5. онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд өөрөө явагч хэрэгсэл нэвтрүүлэх, нисэх онгоц буулгах; 45.3.6. ашигт малтмал эрэх, хайх, ашиглах; 45.3.7. мод, элс, хайрга, чулуу авах.